

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|--|--------------------------------|---------------------|----------------------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Балсангийн Гаваа | Дугаар | L016 |
| Оршин суугаа аймаг | Дорнод аймаг | Оршин суугаа сум | Улаанбаатар хот |
| Төрсөн газар | Дорнод аймгийн Халхгол сум | Төрсөн он | 1941 |
| Ажил мэргэжил | Багш | | |
| Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд | Халхын сүм, Утай уулын хийд | Сүм хийдийн дугаар | ДОХГ 047 ДОХГ 044 |
| Одоогийн сүм хийд | | Сүм хийдийн дугаар | |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 9-р сарын 27 | Ярилцлага авсан хүн | Ч. Хулан |



Дорнод аймгийн Халх гол сумын Халхын сүм, Утай уулын хийд

Тамсагт 3 сүм, Хамгийг хамгаалагч, Соёлыг бадруулагч, Ярууг бадруулагч гэсэн нэртэй. Мөн Отгийн сүм, Гачэн ламын сүм байсан. Энэ зурагт тэмдэглэгдээгүй байна. /Илдэн вангийн хошуу номонд оруулсан зургаа үзүүлэв./ Миний бичсэн номд Халхын сүмийн тухай бий. Халхын сүмийн тухай би 90 гарсан хөгшчүүдээс асууж сурж байсан. Тэр үед асууж сурж байсан зүйлс маань ном, товхимолд орсон байгаа. Дайван сумын нутагт Билгүүт, Хоолойтын сүм гэсэн 2 сүм байсан. Сүүлд Тамсагт нэгдэх гээд чадаагүй, бослого хөдөлгөөн гараад. Баяннуурын баруун талд Отгийн сүм гэж байсан. Тэнд Төвдийн Гачэн лам суудаг байсан. Дашгүндий гэсэн То вангийн байгуулсан нэг жас Сангийн далай орчмын тэнд байдаг. Хийд гэж би сонсоогүй. Их бурхантын хажууханд Бавуу бэйсийн сүм гэж бий. Бавуу бэйс То вангийн ач. 1935 онд Халхын сүмийг Япончууд эзэлж авсан. Лам нар нь өөр

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хийдүүдтэй нэгдсэн. 1936,37 оны үед Халхын 7 сүм нийлж том гэрт Матад сумын Зуухтын Бор тойром гэдэг газар хурж байсан. Аймгаар байгуулсан сүм гэж байсан. Дархан Сөөгийн Хар хошуу гэдэг газар байсан. Би Сан бэйсийн урд хүрээнд сууж байсан Данзан, хойд хүрээнд сууж байсан Лоён гэдэг 2 өвгөнтэй уулзаж байсан. Тэр 2 хоёул Сан бэйсийн хүрээний лам нарын бослогод оролцож байсан. Зогсоо Молом, Жамсран гэдэг 2 хүн бослого гаргаж байсан. Халхын сүм 17-р зууны сүүлчээр баригдсан. Их бурханыг урласан материалын талаар миний сонссоноор өвгөчүүл Хайлаар хотоос чулууг ачиж ачирсан гэж сонсож байсан.

Их бурханд дайны үед сүм тусаагүй нь өөрийнх нь чадалтай холбоотой биз. Зүүн хязгаарыг хамгаалахаар бүтээгдсэн учраас. Жаргалсайхан гуай намайг бага байхад Их бурханы 2 хамрын нүхэнд чоно гөлөглөчихсөн байсныг харж байсан гэж байсан нь хэр том болохыг илтгэнэ.

Халхын сүмийн талаар миний бичсэн болон хэлж байгаа зүйлийг би Халхын сүмд сууж байсан Дамын Самбуу, Бадрахын Шарав нараас асууж лавлаж бичсэн учраас үнэнтэй гэж бодож байна.

Энэ сүм Пун “пунцаг” илдэв вангийн үед буюу 17 зууны сүүлчээр баригдсан. Манжын эзэн хаанаас мэдээтэй, дөчин ламтай, “Махгал” шүтээнтэй сүм байсан. Халхын сүм нь Халхыг барга найман хошуунаас тусгаарласан газар байсан. Халхын сүм Буйр нуурын зүүхэн талд Халх, Шарилж, Оршуун гэсэн гурван голын дунд оршдог. Гадуураа хэрэмтэй, хойно нь Майдарын сүм, Гол сүм, хоёр хажууд нь зүүн, баруун асар сүм, эгц урд нь Үүдэн сүм мөн 2 асар гэсэн долоон дугантай.

Халхын сүмд жил бүрийн зуны сүүл сарын шинийн нэгнээс 14 хоног хошуу хурал хурдаг. Энэ үедээ Гол дуганд маань, үрлийн хурлыг тасралтгүй хуруулдаг, Зүүн, Баруун асар болон бусад дуганд Ганжуур, Данжуурыг, Үүдэн сүмд Арван хангалыг хурдаг байжээ. Хошууны сүсэгтэн ардууд өргөл, мөргөл хийж “Ногоон морины дэг” цам, майдар үзэж, дүнчүүр маанийн хүчээр олшрогдсон үрэл, рашаан утлаганаас хүртдэг байжээ.

1834-1866 оны хооронд То вангийн хошуунд хэд хэдэн сүм дугныг байгуулжээ. Түмэн Өлзийт овооны дэргэд төв ба жигүүрийн хоёр сүм бариулсныг Манжийн хаан “Соёлыг бадруулагч” гэдэг нэрийг өгсөн байна. Мөн То вангийн үед Чойнхордэчлэн буюу “Хамгийг хамгаалагч” сүмийг, Сүжигт ван Дожпаламын үед Паниджуглайлан буюу “Ярууг бадруулагч” сүмийг барьжээ.

Соёлыг бадруулагч, Хамгийг хамгаалагч, Ярууг бадруулагч, Утай таван богд, Намхайбодлын сүмүүдийг нийтэд нь Тамсагийн сүм гэж нэрлэдэг байсан.

Мөн Баян нуурын баруун талд отгийн “Дашдэчэн” гэдэг хурлын газар байсан бөгөөд Гачэн лам энд суудаг байжээ. Отгийн ардууд намар, өвөлдөө дуганаа тойрч намаржиж, өвөлждөг байсан байна. Харчин самууны хөлөөс зайлж тус хошуу нүүхэд сүм хийдүүд нь гэр дугантай нүүдлийн байдалтай явж иржээ.

Сүм хийдийг хааж лам нарыг баривчилж эхлэхэд Матад сумын Зуухтын Бор Тойром гэдэг газар дацангийнхаа гэрүүдийг буулгаж, бурхан сахиусаа их гүнзгий нүх ухаж булж орхисон гэж настайчууд ярьдаг байсан.

Их бурхант бол Монгол улсын шашин соёлын том дурсгал төдийгүй урлагийн хосгүй бүтээл юм. Түгээмэл Элбэгтийн 9-р он буюу 1859 онд Сэцэн хан аймгийн ноёдын чуулганаар Зүүн хязгаар нутгийн аюулгүй

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бадлыг сахин гадны элдэв халдлагаас хамгаалах зорилгоор Халх голын хөвөөнд Жанрайсаг бурхан бүтээх тухай санаа анх гарсан байна. Энэ санаа дэмжигдэн ажил болж 1859-1864 оны хооронд 80 тохой 26 метр урт Жанрайсаг бурханыг чулуугаар урлан бүтээсэн байна.

То ван нутаг хошуундаа шашин номыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байсан бөгөөд XIX зууны Монголын нийгэм улс төрийн томоохон зүтгэлтэн байсан юм. Тэрээр Манжийн дарлалын эсэргүүцэж үйл ажиллагаагаараа энэ бүхнээ харуулж байсан. То ван Монголыг Манжаас тусгаар болгож өөрөө хаан болохдоо суух зорилгоор Тамсаг булагт Манжийн хааны ордны загвараар орд байгуулжээ. Энэ нь Манжийн хааны сонорт хүрч, элч ирэхэд ордны дотор талаар хана гүйлгэж, “Би хааны орд бариулаагүй. Ханат гэр бариулсан ” гэж аргалан өнгөрөөж байсан гэдэг.